



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/27

Хэрлэн сум

**Захиалагчийн хяналтын зардалд
хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг дарга, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга нарын хооронд байгуулсан ЗХ-2022/01 дугаартай гэрээний дагуу төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй барилга байгууламжийн захиалагчийн хяналттай холбоотой зардалд 4,988,400 (дөрвөн сая есөн зуун наян найман мянга дөрвөн зуу) төгрөгийг тээвэр шатахуун, албан томилолтын зардалд зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт данснаас зарцуулахыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.ГАНБААТАР